

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 9 сарын 21 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

## Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотой нэмж гаргах хувьцааны тоо болон үнэ тогтоох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 заалт, 33 дугаар зүйлийн 33.3 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.12, 9.2.12.15 заалт болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Компанид нэгдэж буй “Рэйн Жи Ти Си БЗГ” ХХК-ид санал болгох хувьцааны үнийг компанийн Монголын хөрөнгийн биржийн арилжааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн 20.93 /хорин/ төгрөгөөр тогтоосугай.
- Нэгдэж буй “Рэйн Жи Ти Си БЗГ” ХХК-ийн бизнес үнэлгээ 4,465,306,462 төгрөг байх бөгөөд бизнес үнэлгээнд тулгуурлан компанийн нэмж гаргах энгийн хувьцааны тоо 213,344,790 ширхэг ногдож байгаа тул компанийн нэмж гаргах хувьцааг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулан шийдвэрлүүлсүгэй.
- Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотой нэгтгэх гэрээ, журам болон нэгтгэх төслийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулан шийдвэрлүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 9 сарын 21 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

## Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх хувьцааны үнийг тогтоох, журам батлах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 49 дугаар зүйлийн 49.4 заалт, 53 дугаар зүйлийн 53.1.1, 53.5 заалт, 76 зүйлийн 76.1.7, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.22 заалт болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Компанийг өөрчлөн байгуулах замаар “Рэйн Жи Ти Си БЗГ” ХХК-тай нэгдэхтэй холбоотойгоор үүсэх компанийн хувьцаа эзэмшигчдийн “Тэргүүн ээлжид худалдан авах эрх”, “Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх”-ийг хэрэгжүүлэх үнийг тус тус Монголын хөрөнгийн биржийн арилжааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн 20.93 /хорин/ төгрөгөөр тогтоосугай.
- “Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам, “Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулан шийдвэрлүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ХК



Ч.ЧИНЗОРИГ